



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 111

Улаанбаатар хот

“Үнэт цаас гаргагчийн цахим тайланг ирүүлэх заавар”-ыг батлах тухай

Компанийн тухай хуулийн 83.1, “МХБ” ТӨХК-ийн дүрмийн 8.1, 8.10.9, 8.10.11 дэх заалтууд болон Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын 4.12 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Үнэт цаас гаргагчийн цахим тайланг ирүүлэх заавар”-ыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Мэдээлэл ирүүлэх цахим тайлангийн заавар шинэчлэн батлагдсантай холбогдуулан 2009 оны 157 тоот тушаалын хавсралтыг хүчингүй болгосугай.
3. Цахим тайланг ирүүлэх зааврын дагуу ирж буй мэдээллийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу гэрээгээр хүлээсэн хугацаанд, үнэн зөв ирүүлж буй эсэхэд хяналт тавьж, мэдээллийн сан бурдүүлж ажиллахыг Хяналт шалгалтын алба /Л.Нямдагва/-д үүрэг болгосугай.
4. Мэдээллийг хүлээн авах, боловсруулах, аюулгүй хадгалах техник хангамжийн бэлэн байдлыг бий болгох, програм хөгжүүлэлтийг зохион байгуулж, ажиллахыг Мэдээлэл технологийн алба /З.Батгэрэл/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



М.БОЛОР

000260



**“ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЦАХИМ ТАЙЛАН  
ИРҮҮЛЭХ ЗААВАР” /маягтууд/**

Нэг. Танилцуулга

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 443 тоот тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын 4.12 дугаар заалтыг үндэслэн Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог бий болгох зорилгоор энэхүү “Үнэт цаас гаргагчын мэдээллийн ил тод байдлын цахим тайлангийн заавар /хавсралтанд заасан маягтуудын хамт/-ыг /цаашид “мэдээллийн ил тод байдлын цахим заавар” гэх/ МХБ-ээс боловсруулан гаргав.

Бүртгэлтэй компаниуд энэхүү зааврын дагуу цахим хэлбэрээр тайланг ирүүлэхдээ “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг баримтална.

**Цахим заавар, маягтуудыг ашиглах тухай санамж:**

1. Бүртгэлтэй компанийн эрх бүхий этгээдээс томилсон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь мэдээллийг энэхүү зааврын хавсралтад заасан маягтын дагуу үнэн зөв бөглөж цахим хэлбэрээр / интернэтийн холболтгүй тохиолдолд бичгэн хэлбэрээр/ Монгол хэл дээр ирүүлнэ.
2. Мэдээллийн сангийн бүрдэлтийг хангах зорилгоор компаниудаас интернэт холболтгүйн улмаас бичгэн хэлбэрээр ирүүлсэн мэдээлэл, материалыг Бүртгэлийн албаны компани хариуцсан мэргэжилтэн /цаашид компани хариуцсан мэргэжилтэн гэх/ мэдээллийн санд файл хэлбэрээр оруулж, хадгална.
3. Бүртгэлтэй компаниас цахим хэлбэрээр ирүүлсэн мэдээллийг хянах, хавтаст материалд хадгалах, бүртгэл хөтлөх, боловсруулах, түүнийг нийтийн хүртээл болгох ажлыг компани хариуцсан мэргэжилтэн, харин мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл хүлээн авах болон түгээх үйл ажиллагааны аюулгүй, найдвартай байдлыг Мэдээлэл технологийн алба /цаашид МТА гэх/ хариуцна.
4. Мэдээллийг зааварт заасан хугацаанд ирүүлэхтэй холбоотой ХК-иудын үүргийн хэрэгжилтийг Хяналтын алба /цаашид ХА гэх/ хянаж, хариуцлага тооцно.

**Хоёр. Цахим тайлангийн маягтын ангилал,  
төрөл, тайлагнах хугацаа**

- 2.1. Бүртгэлтэй компаниудаас цахим хэлбэрээр ирүүлэх мэдээллийн маягтыг дараах үндсэн 5 бүлэгт хуваанаа. Үүнд:

- 1-р бүлэг. Компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл
- 2-р бүлэг. ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон бусад Эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл мэдээлэл
- 3-р бүлэг. Санхүүгийн мэдээлэл
- 4-р бүлэг. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл
- 5-р бүлэг. Холбогдох хууль тогтоомжийн мэдээлэл

<i>№</i>	<i>Бүлэг 1. Компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл</i>	<i>Тайллагнах хугацаа</i>
O-1	Үйл ажиллагааны төлөвлөгөө, стратеги түүний хэрэгжилт	Жилээр
O-2	Салбарт эзлэх байр суурь	Жилээр
O-3	Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүсч болох эрсдэл	Жилээр
O-4	Үйл ажиллагааны тогтвортой байдлын тайлан	Жилээр, тухай бүр
O-5	Тайлант хугацаанд гарсан томоохон үйл явдал	Жилээр, тухай бүр
O-6	Нийгмийн хариушлагын тайлан	Жилээр
O-7	Үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх, хувьцааны ханшид нөлөөлөхүйц шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулах	Тухай бүр
O-8	Нийт ажиллагсдын 15 ба түүнээс дээш хувьд өөрчлөлт орох буюу чөлөөлөгдөх, шилжих, шинээр ажилд орох	Тухай бүр
O-9	Компанийн нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах, татан буулгах	Тухай бүр
<i>№</i>	<i>Бүлэг 2. ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон бусад Эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл</i>	<i>Тайллагнах хугацаа</i>
A-1	ТУЗ, Удирдлагын бүтэц бүрэдлэхүүнд орсон өөрчлөлт	Жилээр, хагас жилээр
A-2	ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны мэдээлэл	Жилээр, хагас жилээр, тухай бүр
A-3	ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшуулал, эзэмшиж буй хувьцааны мэдээлэл	Жилээр,
A-4	ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны тайлан	Жилээр
A-5	Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан	Жилээр
A-6	Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийн үзүүлгээний тайлан	Жилээр
A-7	ТУЗ-өөс гаргасан үнэт цаасны ханшинд нөлөөлөх шийдвэр	Тухай бүр
<i>№</i>	<i>Бүлэг 3. Санхүүгийн мэдээлэл</i>	<i>Тайллагнах хугацаа</i>
F-1	Санхүүгийн тайланд хийсэн дүн шинжилгээ	Жилээр, хагас жилээр
F-2	Аудитлагдсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга	Жилээр, хагас жилээр
F-3	Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл	Жилээр, хагас жилээр, тухай бүр
F-4	Өөрийн хөрөнгийн хэмжээ, Хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцаа	Жилээр, хагас жилээр, тухай бүр
F-5	Зээлийн жагсаалт, эргэн төлөлт, барьцаа, баталгаа гаргасан мэдээлэл	Жилээр, хагас жилээр
F-6	Ногдол ашгийн бодлого	Жилээр
F-7	Тухайн жилд хуваарилсан ногдол ашгийн хэмжээ, тарааж буй хэлбэр, тайлбар	Жилээр, хагас жилээр
F-8	Борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ хэлцлийг цуцлах дуусгавар болгох	Тухай бүр
F-9	Хөндөнгийн аудиторын байгуулсан гэрээ, нэмэлт өөрчлөлт	Тухай бүр
F-10	XXX-ийн үнийн дүнгийн 10 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хөрөнгийг худалдах, барьцаалах, бусад хэлбэрээр бусад шилжүүлэх, битүүмжлэх, тусгаарлах	Тухай бүр

F-11	Компани болон түүний толгой, охин болон хараат компаний төлберийн чадваргүй болох	Тухай бүр
F-12	Компанийн орийг хувьцаагаар солих шийдвэр гаргах	Тухай бүр
F-13	Компанийн хөрөнгө, өр төлбөр, хувьцаат капитал болон үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ хэлцэл байгуулах	Тухай бүр
F-14	Компани бусад компанийн хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хувийг худалдах, худалдан авах болсон	Тухай бүр
F-15	Компанийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувийг эзэлдэг үйл ажиллагаатай холбогдох тусгай зөвшөөрөл эзэмших/ хүчингүй болох/ барьцаалах/ аливаа хэлбэрээр бусад шилжүүлэх	Тухай бүр
<i>№</i>	<i>Бүлэг 4. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл</i>	<i>Тайллагнах хугацаа</i>
S-1	Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар	Тухай бүр
S-2	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тайлан, шийдвэр	Жилээр, хагас жилээр, тухай бүр
S-3	Хяналт хэрэгжүүлэгч/ бенефициар эзэмшигчийн мэдээлэл	Жилээр, хагас жилээр
S-4	Хувьцааны опцион, хувьцаа эзэмшигч компанийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх бүхий нэмэлт хувьцаа гаргах	Тухай бүр
S-5	Хувьцаа хуваах, нэгтгэх	Тухай бүр
S-6	Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн өөрчлөлт, тэдгээрийн бусад компанийд хувьцаа эзэмшиж байгаа хувьцаанд гарсан өөрчлөлт	Тухай бүр
<i>№</i>	<i>Бүлэг 5. Холбогдох хууль тогтоомжийн мэдээлэл</i>	<i>Тайллагнах хугацаа</i>
L-1	Үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаа түр, удаан хугацаагаар эсвэл бүхэлдээ зогссон	Тухай бүр
L-2	Үйл ажиллагааны зарим хэсгийг охин, хараат компани болон бусад этгээдүүдэд шилжүүлэх, эсхүл хязгаарлах болсон	Тухай бүр
L-3	Үндсэн болон шинэ бүтээгдэхүүнд зориулан зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, патент, барааны тэмдэг эзэмших болон цуцлагдах	Тухай бүр
L-4	Компанийн оноосон нэр, үндсэн захиргаа, толгой компанийн оршин байх хаяг байршил өөрчлөгдсөн	Тухай бүр
L-5	Компани салбар, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах болсон талаарх мэдээлэл	Тухай бүр
L-6	Компани шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох	Тухай бүр
L-7	Нийт хувьцааны хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон	Тухай бүр

2.2. Компанийн ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга 2.1-д заасан мэдээллийг энэ зааврын хавсралт дах маягтийн дагуу МХБ-ийн мэдээллийн санд байршуулж олон нийтэд мэдээлнэ.

- 2.2.1. Жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор,
- 2.2.2. Хагас жилийн үйл ажиллагааны тайланг жил бурийн 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор,
- 2.2.3. F-7 дахь ногдол ашгийн талаарх мэдээллийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор,
- 2.2.4. Тухай бүр нийтэд хүргэх мэдээллүүдийг мэдээллийн өөрчлөлт орсоноос хойш ажлын 1 өдрийн дотор,

2.3. Мэдээллийг МХБ-ийн компани хариуцсан мэргэжилтэн хянаж ажлын 1 хоногт багтаан олон нийтэд мэдээлнэ

**Гурав. Маягтад мэдээлэл оруулах, түүнийг хүлээн авах, хянах  
болон олон нийтэд хүргэх**

- 3.1. Мэдээллийг холбогдох хууль тогтоомж, гэрээнд заасан хугацаанд компаниас шаардан авч, мэдээллийн санд бүртгэх, түүнийг хянах, олон нийтэд хүргэх ажлыг компани хариуцсан мэргэжилтэн хариуцна.
- 3.2. Энэхүү зааврын хавсралтанд заасан маягтанд холбогдох мэдээллийг тухайн компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга оруулах бөгөөд МХБ-н компани хариуцсан мэргэжилтэн хяналт тавьж ажиллана.
- 3.3. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, албаны компани хариуцсан мэргэжилтэн нар нь тус туслын нууц кодтой байх бөгөөд мэдээллийн санд өөрсдийн кодоор хандаж мэдээлэл оруулна.
- 3.4. Мэдээллийг хавсралтад заасан маягтуудад бичгэн болон тоон, pdf форматаар оруулах бөгөөд ижил төрлийн олон мэдээлэл оруулах шаардлагатай газруудад “Нэмэх” гэсэн сонголтон дээр “enter” товчийг дараахад мэдээний талбар нэмэгдэнэ.
- 3.5. Маягтын “Хавсралт” гэсэн сонголттой хэсгүүдэд шаардлагатай материалыг эх хувиар нь хавсарган ирүүлнэ.
- 3.6. Эрх бүхий этгээдийн гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулах шаардлагагүй материалыг “DOC” өргөтгөлтэй Word, Excel, Power point-ын файлаар ирүүлнэ.
- 3.7. Харин эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан ирүүлэх шаардлагатай тогтоол, тушаал, шийдвэр бусад материалын хуулбарыг scanner-aap хуулбарлан “PDF” өргөтгөлтэй файл хэлбэрээр маягтын холбогдох хэсэгт хавсарган ирүүлнэ.
- 3.8. Хавсаргасан материалын хуулбар дахь үг үсэг, тамга тэмдэг болон түүнд тусгагдсан мэдээллүүд бүрэн гүйцэд харагдахаар тод гаргагтай байдлаар хуулбарлагдсан байна.
- 3.9. Маягтуудын “ Бусад ” гэсэн сонголттой хэсгүүдэд тухайн асуудалтай холбоотой олон нийтэд хүргэх шаардлагатай бусад мэдээллийг оруулж болно.
- 3.10. МХБ-ийн мэдээллийн бааз дахь компанийн холбоотой зарим мэдээлэл нь маягтын холбогдох хэсэгт автоматаар бөглөгдөх боломжтой байна.
- 3.11. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь мэдээний маягтыг бөглөж, “Хадгалагдах” сонголтыг дараахад компани хариуцсан мэргэжилтэнд цахим шуудангаар мэдээлэл ирсэн тухай мэдэгдэл ирнэ.
- 3.12. Компани хариуцсан мэргэжилтэн мэдэгдэл хүлээн авсны дараа ирсэн мэдээллийг агуулгын хувьд хянаж, шаардлага хангасан гэж үзвэл “Нийтлэх” гэсэн сонголтыг дараахад уг мэдээлэл нь олон нийтэд хүргэх хэсэгт бүртгэгдэж, МХБ-ийн web хуудсаар автоматаар үнэ төлбөргүй мэдээлэгдэнэ.
- 3.13. Хэрэв компани хариуцсан мэргэжилтэн нь компаниас ирүүлсэн мэдээлэл, хавсралтаар ирүүлсэн материалыг хянаж, алдаатай буюу мэдээлэл дутуу орсон, түүнийг магадлах шаардлагатай гэж үзвэл тухайн мэдээллийг ирүүлсэн ТУЗ-ийн нарийн бичгийн даргад мэдэгдэж засварыг хийлгэнэ.

- 3.14. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь мэдээллийн дагуу өөрийн оруулсан мэдээллийг хянаж өөрчлөлт оруулах шаардлагатай бол “Засвар” гэсэн сонголтоор холбогдох хэсгийн мэдээллийг шинэчилж, “Хадгалах” сонголтыг дарна.
- 3.15. Олон нийтэд хүргэх хэсэгт бүртгэгдсэн мэдээллийг зөвхөн компани хариуцсан мэргэжилтэн засварлах, өөрчлөх, шинэчлэх эрхтэй байна.
- 3.16. Харин олон нийтэд хүргэх хэсэгт бүртгэгдсэн мэдээлэл нь компаниас тухайн маягтын дагуу шинэ мэдээлэл ирэх бүрд мэдээллийн баазад архивлагдаж хадгалагдана.
- 3.17. Мэдээллийн сан дахь компаниудын мэдээллийг тухайн компанийн болон мэдээллийн маягтын нэрээр эсвэл он сараар хайх, үзэх, судалгаа хийх боломжтой байдлаар хадгална.

### **Дөрөв. Мэдээллийн сангийн нууцлал**

- 4.1. Компаниас мэдээлэл ирүүлэх, шинэчлэх, засвар, өөрчлөлт оруулах, олон нийтэд хүргэх хэсэгт бүртгэх тухай бүр холбогдох ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, мэргэжилтний тус тусын нууц кодоор бүртгэл хөтлөгдөж, мэдээллийн санд хадгална.
- 4.2. Мэдээллийн баазад хандаж мэдээлэл оруулах эрх бүхий ТУЗ-ийн нарийн бичгийн даргад нууц кодыг өгөх бөгөөд түүнийг өөрчлөх, бүртгэл хөтлөх ажлыг Хяналт шалгалтын алба хариуцна.
- 4.3. Компанитай холбоотой мэдээлэл нь мэдээллийн санд хадгалагдах бөгөөд түүнийг албан хэрэгцээнд зориулан хэрэглэх, боловсруулалт хийх боломжтой байна.
- 4.4. Албаны мэргэжилтүүд нь мэдээллийн баазад цахим хэлбэрээр ирүүлсэн мэдээллийг хууль, тогтоомжийн хүрээнд нийтийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийн зах зээл дэх мэдээллийн ил тод, үр дүнтэй байдлыг хангах, компанийн сайн засаглалыг бүрдүүлэх, судалгаа хийх зорилгоор ашиглаж болно.

### **Тав. Хариуцлага**

- 5.1. Нууц кодны нууцлалыг тухайн код эзэмшигч болон Хяналт шалгалтын алба хариуцна.
- 5.2. Мэдээллийн сан дахь мэдээллийн бүрэн бүтэн, найдвартай байдлыг МТА, хариуцна.
- 5.3. МХБ ХК-д цахим хэлбэрээр ирүүлсэн мэдээллийн үнэн зөвийг мэдээлэл ирүүлсэн этгээд, олон нийтэд хүргэх хэсэгт бүртгэгдсэн мэдээллийн үнэн зөвийг компани хариуцсан мэргэжилтэн тус тус хариуцна.
- 5.4. Энэхүү зааврын дагуу ирүүлэх мэдээллийг хууль тогтоомж, гэрээнд заасан хугацаанд зохих маягтын дагуу үнэн зөв бүрэн ирүүлээгүй, компаниас ирүүлсэн мэдээллийг олон нийтэд хүргэх хэсэгт бүртгэхээс өмнө агуулгын хувьд хянаагүйгээс үссэн үр дагаврыг холбогдох хуулийн этгээд, албан тушаалтан хариуцах бөгөөд хууль тогтоомж, “Үнэт цаас гаргагчтай байгуулах гэрээ”-ний дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**I. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ**

<i>№</i>	<i>Мэдээллийн нэр</i>	<i>Мэдээлэл оруулах хэлбэр</i>
O-1	Үйл ажиллагааны төлөвлөгөө, стратеги түүний хэрэгжилт	Text, pdf, doc file хавсаргах
O-2	Салбарт эзлэх байр суурь	Text, pdf, doc file хавсаргах
O-3	Барaa бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүсч болох эрсдэл	Text, pdf, doc file хавсаргах
O-4	Үйл ажиллагааны тогтвортой байдлын тайлан	Text, pdf, doc file хавсаргах
O-5	Тайлант хугацаанд гарсан томоохон үйл явдал	Text, pdf, doc file хавсаргах
O-6	Нийгмийн хариуцлагын тайлан	Text, pdf, doc file хавсаргах
O-7	Үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх, хувьцааны ханшид нөлөөлөхүйц шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулах	Text, pdf, doc file хавсаргах
O-8	Нийт ажиллагасдын 15 ба түүнээс дээш хувьд өөрчлөлт орох буюу чөлөөлөгдөх, шилжих, шинээр ажилд орох	Text, pdf, doc file хавсаргах
O-9	Компанийн нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах, татан буулгах	Маягт O-9

*Мэдээлэл оруулсан огноо:**Шинэчлэгдсэн огноо:*

**Хавсралт 2**

**2. ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА БОЛОН БУСАД ЭРХ БУХИЙ АЛБАН  
ТУШААЛТНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

<i>№</i>	<i>Мэдээллийн иэр</i>	<i>Мэдээлэл оруулах хэлбэр</i>
A-1	ТУЗ, Удирдлагын бүтэц бүрэдлэхүүнд орсон өөрчлөлт	Маягт A-1
A-2	ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны мэдээлэл	Text, pdf, doc file хавсаргах
A-3	ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшуулал, эзэмшиж буй хувьцааны мэдээлэл	Text, pdf, excel file хавсаргах
A-4	ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны тайлан	Text, pdf, doc file хавсаргах
A-5	Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан	Text, pdf, doc file хавсаргах
A-6	Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийн үнэлгээний тайлан	Text, pdf, doc file хавсаргах
A-7	ТУЗ-өөс гаргасан үнэт цаасны ханшинд нөлөөлөх шийдвэр	Маягт A-7

*Мэдээлэл оруулсан огноо:*

*Шинэчлэгдсэн огноо:*

### 3. КОМПАНИЙН САНХҮҮТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

<i>№</i>	<i>Мэдээллийн нэр</i>	<i>Мэдээлэл оруулах хэлбэр</i>
F-1	Санхүүгийн тайланд хийсэн дүн шинжилгээ	Text, pdf, excel file хавсаргах
F-2	Аудитлагдсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга	Text, pdf, excel file хавсаргах
F-3	Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл	Text, pdf, doc file хавсаргах
F-4	Өөрийн хөрөнгийн хэмжээ, Хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцаа	Text, pdf, excel file хавсаргах
F-5	Зээлийн жагсаалт, эргэн төлөлт, барьцаа, баталгаа гаргасан мэдээлэл	Text, pdf, excel file хавсаргах
F-6	Ногдол ашгийн бодлого	Text, pdf, doc file хавсаргах
F-7	Тухайн жилд хуваарилсан ногдол ашгийн хэмжээ, тарааж буй хэлбэр, тайлбар	Маягт F-7
F-8	Борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ хэлцлийг цуцлах дуусгавар болгох	Text, pdf, doc file хавсаргах
F-9	Хөндлөнгийн аудиторын байгуулсан гэрээ, нэмэлт өөрчлөлт	Text, pdf, doc file хавсаргах
F-10	YXX-ийн үнийн дүнгийн 10 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хөрөнгийг худалдаа, барьцаалах, бусад хэлбэрээр бусдад шилжүүлэх, битүүмжлэх, тусгаарлах	Маягт F-10
F-11	Компани болон түүний толгой, охин болон хараат компаний төлбөрийн чадваргүй болох	Text, pdf, doc file хавсаргах
F-12	Компанийн өрийг хувьцаагаар солих шийдвэр гаргах	Text, pdf, doc file хавсаргах
F-13	Компанийн хөрөнгө, өр төлбөр, хувьцаат капитал болон үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ хэлцэл байгуулах	Маягт F-13
F-14	Компани бусад компанийн хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хувийг худалдаа, худалдан авах болсон	Маягт F-14
F-15	Компанийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувийг эзэлдэг үйл ажиллагаатай холбогдох тусгай зөвшөөрөл эзэмших/ хүчингүй болох/ барьцаалах/ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэх	Маягт F-15

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

#### 4. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

<i>№</i>	<i>Мэдээллийн нэр</i>	<i>Мэдээлэл оруулах хэлбэр</i>
S-1	Хувьцаа эзэмшигчийн хурлын зар	Маягт S-1
S-2	Хувьцаа эзэмшигчийн хурлын зар, тайлан, шийдвэр	Маягт S-2
S-3	Хяналт хэрэгжүүлэгч/ бенефициар эзэмшигчийн мэдээлэл	Text, pdf, doc file хавсаргах
S-4	Хувьцааны опцион, хувьцаа эзэмшигч компанийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх бүхий нэмэлт хувьцаа гаргах	Text, pdf, doc file хавсаргах
S-5	Хувьцаа хуваах, нэгтгэх	Text, pdf, doc file хавсаргах
S-6	Нелөө бүхий хувьцаа эзэмшигч, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн өөрчлөлт, тэдгээрийн бусад компанийд хувьцаа эзэмшиж байгаа хувьцаанд гарсан өөрчлөлт	Text, pdf, excel file хавсаргах

*Мэдээлэл оруулсан огноо:*

*Шинэчлэгдсэн огноо:*

## 5. ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН МЭДЭЭЛЭЛ

<i>№</i>	<i>Мэдээллийн нэр</i>	<i>Мэдээлэл оруулах хэлбэр</i>
L-1	Үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаа түр, удаан хугацаагаар эсвэл бүхэлдээ зогсон	Text, pdf, doc file хавсаргах
L-2	Үйл ажиллагааны зарим хэсгийг охин, хараат компани болон бусад этгээдүүдэд шилжүүлэх, эсхүл хязгаарлах болсон	Маягт L-2
L-3	Үндсэн болон шинэ бүтээгдэхүүнд зориулан зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, патент, барааны тэмдэг эзэмших болон цуцлагдах	Text, pdf, doc file хавсаргах
L-4	Компанийн иноосон нэр, үндсэн захиргаа, толгой компанийн оршин байх хаяг байршил өөрчлөгдсөн	Маягт L-4
L-5	Компани салбар, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах болсон талаарх мэдээлэл	Text, pdf, doc file хавсаргах
L-6	Компани шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох	Маягт L-6
L-7	Нийт хувьцааны хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон	Маягт L-7

*Мэдээлэл оруулсан огноо:*

*Шинэчлэгдсэн огноо:*

## Хавсралт 6

**Маягт О-9** компанийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх бүхий нэмэлт хувьцаа гаргах, компанийг нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах зэрэгээр өөрчлөн байгуулах шийдвэр, компанийн хувьцааг хуваах, нэгтгэх шийдвэр, компанийг татан буулгах шийдвэр

1.Хувьцаа эзэмшигчдийн хурал	Ээлжит <input type="checkbox"/> Ээлжит бус <input type="checkbox"/>
1.1 Хуралдсан огноо	..... он ..... сар ..... өдөр ..... цаг
1.2 Хуралдсан газар	
1.3 Хурлын ирц	..... %
1.4 Хэлэлцсэн асуудал /Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлд зааснаас сонгох/	
2.Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр	Санал Хувь
2.1 хавсралт	Зөвшөөрсэн .....
<i>Хавсралт</i>	Татгалзсан .....
хавсралт хавсралт нэмэх	Түдгэлзсэн .....
<i>Хавсралт Нэмэгдэх</i>	
2.3 Хурлын протокол	Хурлын протоколын хуулбарыг хавсаргана. <i>Хавсралт</i>
2.4 Бусад асуудал	

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

**Маягт № А-1** компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад орсон өөрчлөлт

№	Овог нэр	Ажлын газар, албан тушаал	ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүн сонгох	Тухайн компанийд хувьцаа эзэмшидэг бол хувь хэмжээ	Регистрийн дугаар	Анкет, товч танилцуулга, ТУЗ-ийн гишүүнээр томилсон тухай холбогдох шийдвэр
1				...%		
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
<i>Нэмэгдэх</i>						
	ТУЗ-ийн дэргэдэх хороо		Хороо			

№	Овог нэр	Гүйцэтгэх удирдлагын албан тушаал	Тухайн компанийд хувьцаа эзэмшидэг бол хувь хэмжээ	Регистрийн дугаар	Анкет, товч танилцуулга, ТУЗ-ийн гишүүнээр томилсон тухай холбогдох шийдвэр
1			...%		PDF file
2			...%		
3			...%		

*Мэдээлэл оруулсан огноо:*

*Шинэчлэгдсэн огноо:*

## **Хавсралт 8**

**Маягт А-7** компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр, хурлын зар болон бусад холбогдох материал, компанийн ТУЗ-өөс гарсан үнэт цаасны ханшид нөлөөлөх аливаа шийдвэр

1.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал			
Хуралдсан огноо	..... он	..... сар	..... өдөр ..... цаг
Хуралдсан газар			
Хурлын ирц	.....	%	
Хэлэлцсэн асуудал			
2.ТУЗ –ийн шийдвэр	Санал	Хувь	
хавсралт	Зөвшөөрсөн	....%	
<u>Хавсралт</u>	Татгалзсан	....%	
	Түдгэлзсэн	....%	
3.Хурлын протокол	Хурлын протоколын хуулбарыг хавсаргана.	<u>Хавсралт</u>	
4.Бусад асуудал			

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

**Маягт F-7 компанийн ногдол ашгийн мэдээлэл**

Компанийн нэр	Үсгэн код	Шийдвэр	Бүртгэх өдөр	Тараах өдөр	Нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ /төгрөгөөр/
		хавсралт			

*Мэдээлэл оруулсан огноо:*

*Шинэчлэгдсэн огноо:*

**Маягт F-10** компанийн үл хөдлөх хөрөнгийн үнийн дүнгийн 10 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хөрөнгийг худалдах, барьцаалах болон бусад хэлбэрээр бусдад шилжүүлэх, битүүмжлэх, тусгаарлах

1.Компанийн хөрөнгийн дүн		
2.Хөрөнгийн өөрчлөлт /%-р өссөн, буурсан/		
3.Өөрчлөлт орсон хөрөнгө	..... хөрөнгийн гэрчилгээний дугаар	.....
	Нэр	
	Байршил	
	Өөрчлөлт орсон үл хөдлөх хөрөнгийн дүн	..... төгрөг
	Компанийн үл хөдлөх хөрөнгийн үнийн дүн/	..... төгрөг
	Компанийн үл хөдлөх хөрөнгийн үнийн дүнд эзлэх хувь	%
4.Шийдвэр	Дуусах хугацаа	.... сар
	Гаргасан этгээд	
5.Бусад	Огноо	.... он .... сар .... өдөр

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

## Маягт F-13 компанийн гэрээ хэлцлийн талаарх мэдээлэл

1. Гэрээ хэлцлийн утга				
2. Гэрээ хэлцлийн нэр	Шийдвэрийн Дугаар	№.....	Гэрээний хуулбар <u>Хавсралт</u>	
ХЭХ –ын ирц	Нийт	Тоо : .....	Хувь: .....	
	Зөвшөөрсөн	..... ширхэг	..... .%	
	Татгалзсан	..... ширхэг	..... .%	
	Түдгэлзсэн	..... ширхэг	..... .%	
Огноо		..... он ..... сар ..... өдөр		
3. Хэлцэл	Үнийн дүн		..... төгрөг	
	Хийхээс өмнөх сүүлийн балансын нийт активийн дүн		..... төгрөг	
	Үнийн дүнгийн нийт активт эзлэх хувь		..... %	
4. Гэрээний нөгөө тал				
5. Нөхцөл болзол				
6. Хугацаа	Эхлэх	..... он ..... сар ..... өдөр		
	Дуусах	..... он ..... сар ..... өдөр		
7. Гэрээ хийгдсэн огноо		..... он ..... сар ..... өдөр		
8. Бусад				

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

**Маягт F-14** компани бусад компанийн хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хувийг худалдах, худалдан авах болсон

№	Компанийн нэр	Худалдан авах, худалдах компанийн нэр	Одоо эзэмшиж байгаа хувьцааны хувь хэмжээ	Худалдан авах, худалдах хувьцааны хувь хэмжээ
1			....%	....%
2				
3	<u>Нэмэгдэх</u>			

*Мэдээлэл оруулсан огноо:*

*Шинэчлэгдсэн огноо:*

**Маягт F-15** компани борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувийг эзэлдэг үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл /лиценз/ эзэмших болсон эсхүл түүнийг хүчингүй болгосон, барьцаалсан, аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн

1.Компанийн нэр	
2.Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ	Pdf file хавсаргах
3.Эзэмшиж эхэлсэн огноо	..... он ..... сар ..... өдөр
4.Өөрчлөлт орсон шалтгаан	Шалтгаан тайлбарын бичнэ
5.Өөрчлөлт орсон огноо	..... он ..... сар ..... өдөр

*Мэдээлэл оруулсан огноо:*

*Шинэчлэгдсэн огноо:*

**МаягтS-1 хувьцаа эзэмшигчдийн хурлын зар**

1.Хувь нийлүүлэгчдийн хурал	Ээлжит <input type="checkbox"/>	Ээлжит бус <input type="checkbox"/>
2.ХЭХ хуралдах хугацаа	..... он ..... сар ..... өдөр ..... цаг	
3.Бүртгэх өдөр	..... он ..... сар ..... өдөр	
4.Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах өдөр	..... он ..... сар ..... өдөр	
5.Зарлуулсан эх сурвалж /он, сар , өдөр, дугаар/	1. .... /.....он, .....сар ,..... өдөр,..... дугаар/ 2. .... /.....он, .....сар ,..... өдөр,..... дугаар/ 3. .... /.....он, .....сар ,..... өдөр,..... дугаар/	
6.Хуралдах газрын хаяг	1.  2.	
7.Хурлаар хэлэлцэх асуудлууд	3.  4. <u>Нэмэгдэх</u>	
8.Шийдвэр	Гаргасан этгээд Огноо , дугаар	..... он ..... сар ..... өдөр №.....
9.Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн		
10.Холбоо барих утас		

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

**Маягт S-2** компанийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан аяах эрх бүхий нэмэлт хувьцаа гаргах, компанийг нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах зэрэээр өөрчлөн байгуулах шийдвэр, компанийн хувьцааг хуваах, нэгтгэх шийдвэр, компанийг татан буулгах шийдвэр

<b>1. Хувьцаа эзэмшигчдийн хурал</b>		Ээлжит <input type="checkbox"/>	Ээлжит бус <input type="checkbox"/>
1.1 Хуралдсан огноо		.... он .... сар .... өдөр .... цаг	
1.2 Хуралдсан газар			
1.3 Хурлын ирц		.... %	
1.4 Хэлэлцсэн асуудал /Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлд зааснаас сонгох/			
<b>2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр</b>		<b>Санал</b>	<b>Хувь</b>
2.1 хавсралт		Зөвшөөрсөн	.... %
Хавсралт		Татгалзсан	.... %
хавсралт		Түдгэлзсэн	.... %
хавсралт нэмэх		Зөвшөөрсөн	.... %
Хавсралт	<u>Нэмэгдэх</u>	Татгалзсан	.... %
2.3 Хурлын протокол	Хурлын протоколын хуулбарыг хавсаргана.	<u>Хавсралт</u>	
2.4 Бусад асуудал			

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

**Маягт № S-6** компанийн нэлөө бүхий хувьцаа эзэмшигчийн бүтэц, түүний бусад компанийд эзэмшиж байгаа хувьцаанд өөрчлөлт орох

Д/Д	Хувьцаа эзэмшигчид			Тухайн компанийд эзэмшиж буй хувьцаа		Бусад компанийд эзэмшиж буй хувьцаа		
	Овог	Нэр	Албан тушаал	Тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь	Компанийн нэр	Тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь
1.				..... ш	.... %			
2.				..... ш	.... %			
3.				..... ш	.... %			
4.	<i>Нэмэгдэх</i>			..... ш	.... %			

*Мэдээлэл оруулсан огноо:*

*Шинэчлэгдсэн огноо:*

**Маягт L-2** компанийн үйл ажиллагааны зарим хэсгийг охин, хараат компаний болон бусад этгээдэд шилжүүлэх болон хязгаарлах

Компанийн мэдээлэл		Эхний байдлаар оруулах	Орсон өөрчлөлтийг харуулах /өөрчлөлт орсон огноо/
Толгой Компани	Нэр		
	Хаяг		
	Үйл ажиллагааны чиглэл		
Охин Компани <i>Нэмэгдэх</i>	Нэр		
	Хаяг		
	Үйл ажиллагааны чиглэл		
Хараат компани <i>Нэмэгдэх</i>	Нэр		
	Хаяг		
	Үйл ажиллагааны чиглэл		
	Нэр		
Бусад	Хаяг		
	Үйл ажиллагааны чиглэл		

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

**Маягт L-4** компанийн нэр, үндсэн захиргаа болон толгой компанийн оршин байх хаяг байршил өөрчлөгдсөн тухай мэдээлэл

1.Компанийн нэр			
2.Үсгэн код			
3.Огноо			
4.Нэр өөрчлөгдсөн	Хуучин нэр		Эрх бүхий этгээдийн шийдвэр /PDF file/
5.Хаяг өөрчлөгдсөн	Хуучин хаяг		
	Шинэ хаяг		

*Мэдээлэл оруулсан огноо:*

*Шинэчлэгдсэн огноо:*

**Маягт L-6** компани шүүхэд нэхэмжлэгч, хариуцаагчаар оролцох болсон

Компанийн нэр	Хэний өмнөөс	Нэхэмжлэгч / Хариуцагч	Үнийн дүн
1.			
2. <u>Нэмэгдэх</u>			

*Мэдээлэл оруулсан огноо:*

*Шинэчлэгдсэн огноо:*

**Маягт L-7** компанийн нийт гаргасан хувьцааны хяналтын багц эзэмшигчид болон эрх бүхий албан тушаалтнууд нь гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон

Овог нэр	Албан тушаал	Тухайн компанийд эзэмшиж буй хувьцаа	Шүүхийн шийдвэр
1.		..... ш	.... %
2.			

*Мэдээлэл оруулсан огноо:*

*Шинэчлэгдсэн огноо:*